



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/82

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 3 дугаар хэсгийн 3.1.3, 3.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн нягтралыг сайжруулах ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт болон орон сууцны хороолол дотор байгуулах “Ойн төгөл” -үүдэд таригдах гоёл чимэглэлийн мод, сөөгийг нийлүүлэх нийлүүлэгч байгууллагуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.


2. Хотын гудамж, цэцэрлэгт болон орон сууцны хороолол дотор байгуулах “Ойн төгөл”-үүдэд тарих гоёл чимэглэлийн мод, сөөгний байршил, нэр төрөл, тоо хэмжээ, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Гоёл чимэглэлийн мод, сөөг нийлүүлэх нийлүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР




Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 03-р сарын 28 өдрийн
А/82 тушаалын 1 дүгээр хавсралт



ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН МОД, СӨӨГ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ
БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2-р хороо, Чоймболын гудамж 55-64 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн арчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 03-р сарын 28-ны өдрийн
 А/82...тушаалын 2 дугаар авсралт



ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН МОД, СӨӨГ ТАРИХ БАЙРШИЛ,
 НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ, ШААРДАГДАХ ЗАРДАЛ

д.д	Байршил, ажлын нэр	Тарих мод, сөөгний нэр, төрөл, өндрийн хэмжээ	Тоо хэмжээ /ш.бут/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1.	Наадамчдын автозам дагууд /замын урд талаар/ тарих ургамлан хашлаганы сөөг нийлүүлэх ажил	1.Хайлаас /1,0-1,5м өндөртэй/	30000 ш	1000	30.000.000
		2. Хайлаас / 0,7-0,9м өндөртэй/	50000ш	600	30.000.000
2.	Наадамчдын автозам дагууд /замын урд талаар/ тарих гоёлын бут сөөг нийлүүлэх ажил	1.Голт бор /0,8-1,0м өндөртэй модлог/	2320ш	15000	34.800.000
		2.Голт бор / 0,6-0,8м сөөгөн/	2000ш	12000	24.000.000
3.	Бага тойруугийн гудамж /5-р сургуулийн урдаас УБИСургууль хүртэл/-нд тарих гоёлын бут сөөг нийлүүлж тарьж арчлах ажил	1.Хүрэн навчит монос /1,8-2,0 м өндөртэй/	320 бут	110000	35.200.000
		2.Шар навчит хайлаас /1,8-2,0 м өндөртэй/	450 бут	110000	49.500.000
		3.Хүрэн навчит хайтан /1,8-2,3 м өндөртэй/	350 бут	110000	38.500.000
		4. Тэхийн шээг /0,7-0,8 м өндөр/	1200 бут	25000	30.000.000
4.	Их тойруугийн гудамж / Эвтэй 4 амьтны хөшөөнөөс зүүн 4 замын уулзвар хүртэл/	1.Далан хальс /0,7-0,8 м өндөртэй/	200 бут	48000	9.600.000
5.	Орон сууцны хороололд байгуулах "Ойн төгөл"-үүдэд таригдах мод, сөөг нийлүүлэх ажил	1.Гацуур /1,8-2,0м өндөртэй/	350ш	140000	49.000.000
		2.Агч мод /2,0-2,5м өндөртэй/	2500ш	8000	20.000.000
		3.Улиас 2,0-2,5м өндөртэй /	2300ш	4500	10.350.000
6.	Моносын уулзвараас хуучин 22-ын товчооны салдаг уулзвар хүртэл автозамын 2 тал болон голын тусгаарлах зарваст тарих мод, сөөг нийлүүлэх ажил	1.Улиас /2,0-3,0м өндөртэй/	5000 ш	5000	25.000.000
		2.Хайлаас /0,7-0,9м өндөртэй/	60000ш	600	36.000.000
	ДҮН				421.950.000